

**БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГЫГ СОНГОХ ТУХАЙ АСУУДЛААР
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн Б.Энх-Амгалан**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын тухай хуулийн дугаар зүйлийн 7.1.6 дахь заалт, мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг Байнгын хороо 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараахь санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж байна.


Байнгын хорооны хуралдааны үед гишүүд нэр дэвшигчээс асуулт асууж, санал гараагүй бөгөөд Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Энхбаярыг нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Энхбаярыг нэр дэвшүүлсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**



Н.ЭНХБОЛД